

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН
ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2017 оны 08 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 4/241-А/287

Мандалговь хот

Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох,
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3 дахь заалт,
Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.4 дэх
заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ, ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Мандалговь хотын агаарын бохирдлыг бууруулах,
хязгаарлалтын бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд стандартын шаардлага
хангасан бүтээгдэхүүн хэрэглэх, түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, дэглэмийг мөрдөх
харилцааг зохицуулах зорилгоор "Агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүс"-ийг
нэгдүгээр хавсралтаар, "бүсэд дагаж мөрдөх журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус
баталсугай.

Хоёр. Тушаал, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар
хангаж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын
яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга /Г.Нямдаваа/,
Дундговь аймгийн Засаг даргын орлогч /Ж.Мөнхчулуун/ нарт даалгасугай.

